

МОНГОЛЫН УГСААТНЫ ЗҮЙН ҮНДЭС

Урадын Э. Булаг

Сүүлийн хэдхэн жилд Монголд нийгэм, соёлын антропологийн судалгааны хоёр байгууллага бий болсон нь Монгол улсын их сургуулийн Нийгэм, соёлын антропологийн тэнхим (2006), Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн Угсаатан судлал, нийгэм-соёлын антропологийн салбар (2010) хоёр юм. Эдгээр нь хуучин “Угсаатны зүй”-н тэнхим, тасагт суурилсан тул шинээр үүссэн байгууллага биш юм. Ийнхүү “нэрээ шинэчилсэн” нь 1992 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ыг Монгол Улс хэмээн өөрчилсөн шиг нийгмийн “дэг журмын өөрчлөлт”-ийг илтгэнэ. Улс нэрээ сольж, социалист үзэл суртал, зөвлөлтийн нөлөөнөөс салах гэсэнтэй адил зөвлөлтийн загвартай угсаатны зүйгээс илүүтэй Өрнөдийн нийгэм, соёлын антропологид шилжих гэсэн оролдлого болжээ. Энэ явцад өмнөх үеийн угсаатны зүйчдийн нөлөө суларч, Европ, Америк, Японд бэлтгэгдсэн шинэ антропологичдоор хүчээ сэлбэж байна.

Ингэж шинэ чиг хандлага бий болсноор 1920-иод онд үүсч, 1950, 60-аад онд институтчлэгдэж, 1970-1980-аад онд хөгжин цэцэглэж ирсэн Монголын угсаатны зүйн бүхий л үйл явцыг эргэн харах шаардлагатай болж байна. 1990-ээд оны эхээр Монгол Улсын Төв номын сан олон тооны хуучин номоо хэт коммунист, үзэл сурталжсан нэрийдлээр гаргаж хаясан шиг энэ урт хугацаанд туурвисан бүтээлээ түүхийн тоосонд дарах гэж үү? Эсвэл өвөрмөц соёлыг сонирхдог цөөн хэдэн хүнд зориулан нуун дарагдуулсаар байх уу? Харин ХХ зууны монголын сэхээтнүүдийн хосгүй өвийг бүтээх ажил гэж үзээд олон нийтэд хүргэх хэрэгтэй юү? Энэ бол тулгарч буй гол асуудал юм.

Шүүмжлэлт байр суурьтай Өрнөдийн нийгэм, соёлын антропологид ч үзэл баримтлал, практикийн алдаа дутагдал байсныг колоничлолын дараах үеийн судалгаанд ихээхэн шүүмжилсэн байдаг. Сүүлийн үеийн “Өрнөдийн” антропологийг “колоничлолоос салгах”, “дэлхийн антропологи”-ийг дэмжих оролдлого нь Өрнөдийн антропологи дэлхийд тэргүүлж байгаа ч гэлээ монополь биш, тийм байх ч ёсгүй гэдгийг харуулах гэсэн нээлттэй илрэл мөн. Өрнөдийн антропологид олон нийтийн дуу хоолой дутмаг байдаг нь судлаж буй нийгэм, соёлынхоо үйл явцад ихээр “нөлөөлөх” үү, эс бөгөөс “шүүмжлэлт зайгаа” барих уу гэж маргаж ирсэнтэй нь холбоотой. Харин Монголын угсаатны зүй, монголын түүх, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт, судалгаа сургалтанд голлон

оролцох эрхтэй байснаараа ялгаатай юм. Монголын угсаатны зүйчид “нутгийн антропологчид”-ын хувьд түүхч, хэл шинжлэлч болон бусад эрдэмтэдтэй хамтран монгол үндэсний соёлын хил хязгаар, агуулгыг тогтоон тодорхойлж иржээ. Сайнтай ч муутай ч тэд бүтээлээрээ Монголын үндэстэн ястны тухай ойлголтод шууд нөлөөлж, одоо ургийн овог болгон хэрэглэж байгаа “овгийг” “сэргээн” нэвтрүүлсэн байна.

Монголын нийгэмд туссан угсаатан судлалын энэхүү нөлөөг Монголыг сонирхдог, тэр дундаа “уламжлалт соёл” хөдөө хадгалагдаж ирсэн гэж үздэг хүмүүс ойлгох нь чухал. XX зууны турш Монголын угсаатны зүйчид соёлын тухай ойлголт төсөөллийг нь шинээр боловсруулан бүтээсэн тул хөдөө бөглүү суудаг малчид заавал эртний “уламжлалт” олон үзэл санааг хадгалж ирсэн байх албагүй. Иймээс Монголын уламжлалт болон шинэ үеийн соёлын үүсэл, хөгжлийн асуудлыг судалж буй хүн социализмын үед угсаатны зүйчдийн туурвисан бүтээлүүдтэй сайтар танилцах нь зохилтой.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академиийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор Г.Цэрэнхандыг 2009 оны өвөл Кэмбрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төвийн (MIASU) урилгаар Кэмбрижид хоёр долоо хоногийн хугацаанд зочлох үеэр Монголын угсаатны зүйн судлалын өнөөгийн байдлын талаар тодруулсан. Би 2010 оны намар Түүхийн хүрээлэнд богино хугацаагаар зочлохдоо хүрээлэнгийн архивт дарагдсан хээрийн судалгааны тайланг ил гаргаж хэвлүүлэх нь зүйтэй гэсэн санал тавьсныг хүрээлэнгийн захирал С.Чулуун ажил хэрэгчээр дэмжсэн юм. 2011 оны хавар С.Чулуун захирал MIASU-д зочлох үеэрээ угсаатны зүйн олон боть тайлан хэвлэх хоёр байгууллагын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан юм.

Энэхүү хэвлэлийн ач холбогдлыг дурдахгүй өнгөрч боломгүй. 1960-аад оны үеийн хээрийн судалгааны эх тайлангууд 1960-аад оноос шинэ мянганы эхэн хүртэлх үеийн угсаатны зүйн олон бүтээлийн суурь болж байдаг. Монголд ном хэвлүүлэхэд хаана ч байдагтай адил хянан засуулахын зэрэгцээ саяхныг хүртэл эрдэмтэд үзэл суртлын хороогоор батлуулдаг байсныг бид мэднэ. Иймээс эх тайланг уншаад юу хасч, юу нэмснийг олж харах нь онцгойлон сонирхол татаж байна. Нөгөө талаас эдгээр тайлан нь дахин хээрийн шинжилгээ хийн засаж болохооргүй олон тоо баримт, мэдээллийг агуулдаг учраас бие даасан угсаатны зүйн судалгаа болж байсан юм. Гэхдээ энэ бол анхаарал татсан цоо шинэ мэдээлэл юмуу огт “боловсруулаагүй мэдээ” байсан гэсэн үг ч бас биш юм. Эдгээр нь тухайн үед мөрдөгдөж байсан тодорхой загвар, онолын хүрээ, зарим нийтлэг хяналт шалгалтын дагуу боловсруулж, хээрийн судалгааны ажлын үр дүнг илтгэж, Түүхийн хүрээлэнд тушаасан тайлан ажээ.

Хээрийн судалгааны ажлын тайланг ийнхүү хадгалах туршлага 1960-аад оноос эхэлсэн ч эхний хэдэн жилдээ энэхүү журмыг чанд мөрддөггүй байжээ. Иймээс зарим хээрийн судалгааны тайлан архиваас олдохгүй байгаа нь огт бичээгүй юм уу алга болсон юм уу гэдэг нь тодорхойгүй байна. 1990-ээд оны эдийн засаг, улс төрийн хямрал байгууллагын үйл ажиллагаанд ул мөрөө үлдээсэн нь тодорхой

юм. Бид Түүхийн хүрээлэнгийн архивт байгаа хээрийн шинжилгээний тайланг хэвлэснээр Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгээс явуулсан Монголын угсаатны зүйн судалгааг харуулах болно.

Хэвлэн нийтэлж буй эдгээр тайланг уншихад дөхөмтэй болгох зорилгоор угсаатны зүйн хөжлийн түүхэн товчоог Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн туршлагад тулгуурлан энд харууллаа. Угсаатны зүйч болон тэдний бичлэгийг өөрийн үзэл бодол мэдлэгийн хүрээнд сонгож, дүн шинжилгээ хийсэн бөгөөд тайланд тайлбар хийхийг зорьсонгүй.

### **Монголын угсаатны зүй бүрэлдэн тогтсон нь**

Евроазийг эзэлсэн тэртээх XIII зууны үеэс л Монголчууд дэлхий нийтийн айдас, сонирхол, гайхшралыг төрүүлж ирсэн. Дундад зууны үеийн Монголчуудын уламжлал, ахуйн хэв маягийн талаар католик шашны төлөөлөгч, хятадын жуулчин, судлаач нар тэмдэглэн үлдээсэн нь одоо үнэт эх сурвалж болж байна. Монголчууд бусад эзлэн түрэмгийлэгчдийн нэгэн адил өөрийн эзэлсэн орныхоо тухай бичиж үлдээгээгүй нь тэд бусад улс үндэстнийг бүлэглэн ангилж, удирдан захирч байгаагүй гэсэн үг биш тул соёлын хүчирхэг ул мөрөө өөр олон арга замаар үлдээж байжээ. Дундад зууны Монголчууд өөрсдийн сэргэн мандалт, дэлхийг байлдан дагуулсан тухайгаа ордны түүхчдээр бичүүлдэг байсны нэг нь анхны “дэлхийн түүх” ч гэж нэрлэгддэг Ил хаадын ордны Рашид ад-Диний бичсэн “Судрын чуулган” юм. Өөрсдийнх нь бичиж тэмдэглэсэн нь Монголын хаад, тэдний удмынхны дунд л “нууц” болон үлджээ. XVII зуунд Монголчууд Манжийн захиргаанд орж, Манжууд Монголчуудыг монгол ёсоор нь удирдан захирах албан бичиг үйлдэх болсонтой зэрэгцэн үндэсний түүх бичлэгийн уламжлал бүрэлдэн тогтсон байна. Тэдгээр бичлэгт монголчуудын тухай арвин мэдээлэл байх авч орчин цагийн угсаатны зүй, антропологийн мэдлэг болж чадахгүй. Харин XIX зууны дунд үеэс Европ болон Оросын аялагчдын бичсэн аян замын тэмдэглэл монголын угсаатны зүйн анхны үрийг тарьсан юм. Монголын эрдэмтдийн өөрсдийн нь бий болгосон угсаатны зүйн үүсэл хөгжлийг түүхэн ийм нөхцөлд үнэлж дүгнэх хэрэгтэй.

Гадаад Монголын Ардын засгийн газар байгуулагдсан 1921 онд Шинжлэх ухааны академийн суурь болсон Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар Монголын өөрийн угсаатан судлалын бүтээн байгуулалт эхэлсэн гэж үзнэ. Буриад Монголын эрдэмтэн Жамсрангийн Цэвээн (Жамсрано) энэ байгууллагыг анх санаачилсан бөгөөд 1921 – 1932 онд тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан.

Ж.Цэвээн бүр 1903 оноос буюу Санкт-Петербургийн Их сургууль, Төв ба Зүүн Азийн судлалын Оросын хорооны дэмжлэгтэйгээр Буриад, Халх Монгол, Өвөр Монгол зэрэг Монголын газар нутгуудаар явж экспедици хийж эхэлсэн үеэсээ монголын угсаатны зүйг сонирхож байжээ. Ж.Цэвээн тэр үеийн буриадын үндсэрхэг үзэлтэн, сэхээтнүүдийн адил бүх Монголчуудыг нэгэн улсын доор

нэгтгэнэ гэж итгэдэг нармай монгол үзэлтэй боловч нармай монгол үзлийн үндэс тэднээс ялгарч байсан нь эхэн үеийн тэмдэглэл, бүтээлүүдээс нь харагддаг. 1911 оны 12-р сард тусгаар тогнолоо олсон Монгол улс байгуулагдсанаас хойш Ж.Цэвээн өөрийн үзэл санаандаа хөтлөгдөн шинэ Монгол үндэстэн бүтээн байгуулах, Монголын хүн амыг соён гэгээрүүлэхэд өөрийн хүчээ зориулжээ. 1910-аад онд Монголын анхны сонин, сэтгүүлийг эрхэлж, орчин үеийн үндэсний анхны сургуулийг удирдаж байв. 1921 онд Монгол Ардын Нам (МАН)-ын төв хороонд эрмэлзэх арван зүйлийг боловсруулж оруулсан байна (Цэвээн 1997: 35).

Монголын орчин үеийн шинжлэх ухааныг хөгжүүлэх томоохон зорилготой эрдэмтэн-улс төрч Ж.Цэвээн угсаатан судлалд онцгойлон сонирхолтой байснаа эхэн үеийн бүтээлээрээ болон 1926 онд Фридрих Энгельсийн “Гэр бүл, хувийн өмч ба төрийн үүсэл” гэсэн номыг орчуулснаараа илтгэн харуулсан. Оросын эрдэмтдийн хамтаар хэд хэдэн экспедиц зохион байгуулсныг “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын угсаатан болон хэл зүйн газрын зураг”- т харуулсан байдаг (Ринчен, 1979). Судар бичгийн хүрээлэн, Оросын шинжлэх ухааны академийн хамтран ажиллах таван жилийн төлөвлөгөөг хураангуйлан бичсэн өгүүлэлдээ тэрээр хамтарсан 12 баг байгуулагдсаны нэг нь “угсаатны зүйн судлалын баг” байсныг дурджээ (Цэвээн 1930, [1997]: 55). Ж.Цэвээн, сүүлд монголын утга зохиолын нэртэй эрдэмтэн болсон буриадын залуу эрдэмтэн, Бямбын Ринчен нарын хамтран бичсэн он нь тодорхойгүй өгүүлэлдээ шинээр хамтран хийх судалгааны зорилгыг тодорхойлжээ. Уг өгүүлэлээ хоёр хэсэгт хуваасан бөгөөд эхний хэсэгт газар зүй, геологи, этноботаник, мал аж ахуй, хөдөө аж ахуйн талаар бичсэн байхад хоёр дахь хэсэгт ард хүмүүсийн шинжилгээний талаар бичжээ (Цэвээн, Ринчен, [1997]). Угсаатны зүй гэж юуг хэлэх вэ гэдгийг үндэслэгч хоёр эрдэмтэн нь энд анх удаа хэлэлцсэн гэдэг тул энэхүү хоёрдугаар хэсгийг дэлгэрүүлж өгүүлэх нь зүйтэй болов уу.

Ж.Цэвээн, Б.Ринчен нар “ethnography” (оросоор этнография) –ийг “хүн аймгийн судлал” гэж орчуулаад “олон хүн аймаг, овог ба тэдгээрийн соёл, иргэншил, ахуй, заншил, хууль зэргийн талаарх судалгаа мөн” гэж тодорхойлжээ (мөн тэнд, 68). Угсаатны зүй бол хүний нийгмийн соёл, иргэншил, үүсэл, хөгжлийг ойлгоход тустайгаас гадна тэдний хөрш хоорондын харилцан нөлөөллийг ойлгоход хувь нэмэр оруулдгаараа хэл шинжлэл, социологи гэх мэт бусад салбар ухаантай холбоотой гэж үзжээ. Иймээс угсаатны зүйн судалгааны сэдэв нь “хууль, ёс заншил, шашин, шүтлэг, залбирал мөргөл, овог үндэсний ялгаа, ардын уран зохиол, түүх, тууль, дуу, шүлэг” зэргийг хамрах нь зүйтэй гэсэн байна. (мөн тэнд, 69).

Монголын угсаатны зүй эсэргүүцэлтэй тулгарч байсан тул Ж.Цэвээн, Б.Ринчен нар Маркс, Энгельсийн угсаатны зүйн баримт ашиглах жишээнээс эшлэн бичиж, үзэл бодлоо хамгаалж байжээ. Угсаатны зүй бол нийгэмд сөргөөр нөлөөлөх зүйлсээс зайлсхийж, эрүүл зүйлийг хамгаалахад тустай гэж үзжээ. Хүмүүсийн хувцас оёдгийг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хувцастай харьцуулан угсаатны зүйн үүднээс судлахад гараар оёход цаг их алддагийг харуулсан нь

Монголын эдийн засгийн хувьд ач холбогдолтой. Угсаатны зүйн энэхүү судалгаа нь эмч, багш, оюутнуудад бодит байдлыг ойлгож, үр бүтээмжтэй ажиллахад нь тустай болно. Овог яс, ёс заншил, хэв хууль, гэр бүл судлах нь үндэсний хууль боловсруулахад дөхөм болохын зэрэгцээ хүүхдэд таниулах ач тустай. Ардын уламжлал болсон тоглоом, наадгай, түүх, эвлүүлдэг тоглоом зэрэг нь хүүхдэд зориулсан ном, унших материал бэлтгэхэд чухал юм (мөн тэнд, 69-70).

Ж.Цэвээн, Б.Ринчен нар дараа нь XIII – XIV зууны үед Монголд аялсан Плано Карпинийн Жон, Рубруккийн Виллиям, Марк Пологийн аян замын тэмдэглэлээс эхлээд XIX зууны үеийн Оросын аялагч Тимковский, Бичурин, Клеменц нарын тэмдэглэлийг багтаасан монголын угсаатны зүйн судлалын түүхийг танилцуулсан байна. Тэдгээр бүтээлийг сонирхолтой, ач холбогдолтой гэж сайшаасан ч шинжлэх ухаанч бус, хэлний мэдлэггүйгээс болсон алдаа их байсныг шүүмжилжээ. Монголын угсаатны зүйн жинхэнэ судалгааг XIX зууны сүүл үед Потанин, Позднеев нар хийсэн гэж тэмдэглэсний зэрэгцээ 1930 онд хийсэн Гржимайлогийн физиологи, төрх байдалд хийсэн антропологийн судалгаа, Баруун Монголын Соёд, Хасаг, Торгууд, Хошууд, Дөрвөд, Баяд, Мянгад, Өөлд, Захчин, Хотгойд, Хотон, Халх овогтны зан заншил, ахуй амьжиргаа, засаг захиргаанд хийсэн угсаатны зүйн шинжилгээг онцлон авч үзсэн байна. Эдгээр судалгааны монгол орчуулга байхгүй нь харамсалтай гэж тэмдэглэжээ.

Ж.Цэвээн, Б.Ринчен нар илтгэлдээ угсаатны зүйн үйл ажиллагааныхаа улс төрийн шалтгааныг дурдаагүй боловч угсаатны зүйн шинжилгээний ихэнхийг баруун Монголд явуулсан нь тодорхой байна. Шинээр байгуулагдсан бүгд найрамдах улс юун түрүүнд нийт хүн амын дунд баг итгэж ирсэн язгууртны хийгээд Буддын шашны сүм хийд хосолсон байгууллагыг голлон анхаарах шаардлагатай байлаа. Монгол Чин гүрнээс тогтоосон феодал эрх мэдлийг язгууртнуудад олгосон аймаг хошууны зохион байгуулалтай байсан бөгөөд засаг захиргааны энэхүү хуваарийг одоогийн Улаанбаатар тэр үеийн Их хүрээнд суурилж, Жавзандамба Хутагтын тэргүүлсэн Бурхны шашны сүм хийдүүд халж, Монгол даяар сүсэгтэн олонтой хамжлагын харилцаа бий болгосон. Энэхүү харилцаа мөлжлөгийн шинж чанартай байлаа. Үүнээс гадна Халх монголчууд баруун монголд төвлөрсөн бусад жижиг бүлгүүдийг хавчин түрэмгийлэх хүчин болсон нь “үндэсний асуудал” мөн хэмээн МАХН тунхаглажээ. МАХН-ын 1925 оны програмд өгүүлэхдээ:

“БНМАУ-ын дотор багтсан олон угсааны жинхэнэ ардын эрх чөлөөг тэгш үзэх ба өөрийнхөө жинхэнэ ардын ашиг тусыг нэгэн хэмээн мэдэж, нийтийн дайснаас мөнхүү ашиг тус юугаа нийтийн хүчээр хамгаалах” гэжээ (Булаг 1998: 39).

Монголын нэрт угсаатны зүйч Бадамхатан 1980 онд ийнхүү бичжээ:

“Хувьсгалын эхний жилүүдэд намын удаа дараагийн хурлаар олон ястан, угсаатныг анхааран авч үзэж, Жавзандамба хутагт, Дөрвөд Зоригт вангийн хамжлагаас чөлөөлөгдсөн хотон, дархад, урианхай ард түмний ахуй амьдрал, соёл боловсролыг дэмжих талаар тогтоол шийдвэр гаргажээ. Энэ бол ястан угсаатнуудад улс төрийн тэгш эрх олгож байгаа томоохон алхам болсон байна”

(Бадамхатан 1980: 17, Булагийн эш татсанаар 1998, 38-39).

Баруун Монголын олон бүлгүүдийг судалсан угсаатны зүйн эхэн үеийн судалгаа нь зүгээр нэг эрдмийн ажил байгаагүй, харин “бага ястан” хэмээн нэрлэгдэж байсан бусад бүлгийг “чөлөөлснөөр”, Монгол дахь язгууртны болон шашны ноёрхлыг устгах гэсэн улс төрийн том үйл ажиллагааны нэгэн хэсэг байсан нь тодорхой юм. Энэхүү үйл ажиллагаа нь “угсаатны бүлгүүдийг” бий болгосон төдийгүй үндэстэн-улс байгуулах Өрнөдийн загварыг баримтлан хүн амыг олонхи, цөөнхи хэмээн хоёр ангилснаар угсаатны тоон шатлалыг бүтээжээ.

Ж.Цэвээн, Б.Ринчен нар Монголын улс төрийн амьдралын тун эгзэгтэй үед бүтээлээ туурвиж байсныг нийтгээрээ мэднэ. Монгол Улсын Ерөнхий сайд байсан Анандын Амар (1928 - 1930) 1930 онд Судар бичгийн хүрээлэнгийн захирлаар томилогдоод уг байгууллагын нэрийг Шинжлэх ухааны хүрээлэн хэмээн нэрлэж, Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Академитэй олон талын хамтын ажиллагааг эхлүүлсэн юм. Оросын олон эрдэмтэн Монголын Шинжлэх ухааны хүрээлэн дээр ажиллахаар Москвагаас ирж байлаа. Ж.Цэвээнийг 1931 оны эхээр хэт барууны үзэлтэн, феодализм болон капитализмын үзэл баримтлалыг дэвэргэгч хэмээн буруутгаж, 1932 онд Ленинградын Их сургуулийн Дорно судлалын хүрээлэнд ажиллуулахаар Монголоос явуулав. Тэрээр 1937 онд баривчлагдаж, 1942 онд нас баржээ. Б.Ринчен мөн л 1937 онд баривчлагдаад 1942 онд суллагдаж Их хэлмэгдүүлэлтийг даван туулсан билээ.

Ленинградад ажиллах хугацаандаа Ж.Цэвээн *“Дархад, Хөвсгөл нуурын урианхай, Дөрвөд, Хотон, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Дарьганга, Алтайн урианхай, Хасаг, Хамниган нарын гарал үндэс байдлын тухай өгүүлэл”* 1934 онд бичиж хэвлүүлсэн нь БНМАУ-ын үндэстний цөөнхийн тухай анхны номд тооцогддог. Мөн тэр онд А.Амарын *“Монголын товч түүх”*, Л.Дэндэвийн *“Монголын товч түүх”*, Д.Лосол, Г.Дэмчиг нарын *“Монгол ардын үндэстний хувьсгалын үүсэж байгуулагдсан товч түүх”* зэрэг Монголын түүхийн гол номнууд хэвлэгдэн гарчээ. Эдгээр ном БНМАУ байгуулагдсаны 10 жилийн ойтой давхцахын зэрэгцээ уг бүтээлүүдэд хэт үндсэрхэх үзэл баримтлал шингэснийг Япончууд Манжуго улс байгуулж, нармай Монголын үзлийг дэмжиж байсны дараах нөхцөл байдал, Монголын талаар баримтлаж буй шинэ Коминтерн, Зөвлөлтийн гадаад бодлоготой холбон ойлгох нь зүйтэй. БНМАУ энэ үед өмнөх жилүүдэд хэрэгжүүлж байсан ЗХУ-тай албан хүчээр адилсуулах, ижилсүүлэх гэсэн бодлогын оронд Японы нармай монгол түрэмгийллийг эсэргүүцэх зорилгоор өөрийн соёл, ижилслийг дэлгэрүүлэх болсон байна. Иймд Ж.Цэвээн дээрх бүтээлдээ БНМАУ төвт үндсэрхэг үзлийг Коминтерн, Зөвлөлт холбоот улсаас дэмжиж эхэлснийг харуулснаас гадна явцуугаар тодорхойлсон Монгол үндэстэн байгуулах үйл явцад хувь нэмрээ оруулсан гэж дүгнэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл, Өвөр Монголчуудыг Хятад, Японы дарлалд зовж байгаа гэж үзээд коммунист нармай Монгол үзэлдээ Буриад, Өвөр Монголыг багтааж байсан бол одоо Өвөр Монголын монголчуудыг социалист Монгол улс оршин тогтноход аюул учруулах Японы дарангуйллын гар хөл гэж үзэх болжээ. Ийм

нөхцөлд Ж.Цэвээний номонд зөвхөн БНМАУ-ын нутаг дэвсгэрт оршдог Халх бус бүлгүүдэд анхаарсан байдаг нь гайхах зүйлгүй юм.

Ж.Цэвээний угсаатны зүй бол өмнөх эх сурвалжийн мэдээлэл, өөрийн болон бусад хүмүүсийн хээрийн шинжилгээний ажлын тайлангийн нэгдэл юм. Тэрээр бүлэг тус бүрийн үүсэл гарал, бүтцийн талаар суурь мэдээллийг нэгтгэж гаргасан юм. Хэдийгээр нармай монгол үзлийн ном биш боловч бүх бүлгийг Монгол угсаатай гэж үзсэн байдаг.

Ж.Цэвээний дээрхи бүлгүүдийг ангилан нэрлэсэн нэр томьёо ихээхэн сонирхолтой юм. Тухайлбал, Дархадын талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн бөгөөд “Дархадууд Түрэг үндэстэй Урианхайтай адил ястай” хэмээн тодорхойлжээ (х.78). Дөрвөд бол Монгол үндэстний нэгэн салбар мөн (х.92). “Ястан” гэдэг нэр томьёогоор Ж.Цэвээн дөрвөд доторх Чорос, Хошууд, Хойд болон бусад эртний овог ясыг нэрлэжээ. (х.93). Харин Баядыг Чингис хааны үед байсан “монгол үндэстэн” гэж нэрлээд “түрэг үндэстэн дотрох нэг яс аймаг” хэмээн тэмдэглэжээ (х.101). Тэрээр Дархад, Халх, Хотгойд, Баяд зэргийг ястан гэж нэг л удаа нэрлэжээ (х.102). Өөлд бол нэгэн “их ясны нэр” гэж бичсэн байна (х.103). Эцэст нь “дээр дурьдсан Дөрвөд, Өөлд, Торгууд, Захчин, Хойд, Хошууд бол бүхэлдээ дөрвөн Ойрдын аймгууд мөн .... Хэл аялгуу, ёс заншлаараа бага зэрэг ялгардаг ч ихэнх нь Монгол үндэстэн мөн” гэж дүгнэжээ (х.108).

Ж.Цэвээн үүнээс өмнө хэвлүүлж байсан бүтээлүүддээ “ястан” гэдэг үгийг бараг хэрэглэж байгаагүйг энд заавал дурьдах ёстой. Халх болон бусад Монгол бүлгүүдийг монгол “овогтон” эсвэл “аймаг” гэжээ. Эндээс гаргаж болох цорын ганц дүгнэлт нь дээрх гурван нэр томьёог хольж хэрэглэж байснаас гадна түүгээр нэгэн “үндэс”-тэй гэгддэг Монголчуудын угсаа гарлыг илэрхийлсэн байна. Түүний үзэж буйгаар жишээ нь Дөрвөд ястан бол Монгол ясан холбоотой олон бүлгийн нэг буюу яах аргагүй “Монгол ястан” мөн болох нь. Эндээс Ж.Цэвээний хэрэглэсэн *ястан* гэдэг үг нь одоогийн “угсаатны бүлэг” гэдгийн утга байгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол үндэстэн гэдэг нь капитализм, социализмын үед л бий болсон улс төр, соёлын хувьд бүрдэл, орчин цагийн зохион байгуулалт мөн гэсэн утга санаа агуулаагүй. Харин Монголчууд бол Түргүүдийн нэгэн адил эрт цагт бүрэлдсэн ураг төрлийн холбоотой томоохон бүлэг, эсвэл нэг *үндэстэй-хүмүүс (үндэс+тэн)* бөгөөд *овогтон, ястан, аймаг* гэж нэрлэдэг олон салаа бүлэгтэй гэж үзсэн.

1920-иод оноос угсаатны бүлгийг албан ёсоор *ястан* гэж нэрлэх болсон Ж.Цэвээний бүтээлд дээрх үгнүүдийг хэрэглэсэн байдал нь нэлээд гайхашрал төрүүлмээр байна. Нэр томьёоны хувьд ингэж нийцэхгүй байгаа нь Ж.Цэвээн *ястан* гэдэг нэр томьёог анх зохиосон гэсэн таамаглалд эргэлзээ төрүүлж байгаа юм (Булаг 1998: 31). Бидний мэдэж байгаагаар энэ нэрийг анх 19-р зууны сүүл үед Буриадуудыг Оросын нэг угсаатны бүлэг гэж тодорхойлохын тулд “зон” (бүлэг) гэдгийн тодотгол болгон хэрэглэсэн. Үүнийг Хобитаев Ширавнямбуу гэдэг буриад хүний 1886-1887 онд бичиж дуусгасан “*Орос их гүрний зүүн Сибирийн хорь буриад хэмээх ястан зоной тэргүүн гарсан ба түүний 11 омгийн түүх бичиг*

оршвой” гэж заасан байдгийг Г. Цэрэнханд 1987 онд эш татсан байна [2005]: 103.

### **Мэргэжлийн угсаатны зүйн судлал бий болсон нь**

Сандагсүрэнгийн Бадамхаган Москвагийн их сургуулийг угсаатны зүйн мэргэжлээр 1957 онд төгсөж ирээд Монголын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүхийн тасагт судлаачаар ажиллаж эхлэх хүртэл Монголд мэргэжлийн бэлтгэгдсэн угсаатны зүйч байсангүй. Тухайн үед Түүхийн хүрээлэн археологи, угсаатны зүй гэсэн салбартай байсан байгууллагын бүтэц 1980-иад оны дунд үе буюу археологийн салбар Академийн дотор бие даасан хүрээлэн болж гарах хүртэл хэвээр байсан. Дээхэн үед Түүхийн хүрээлэн угсаатны зүйн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулсан түүх, археологийн нэрт эрдэмтэн судлаачидтай байсан юм. Жишээлбэл, Х.Пэрлээ гуайн 1975 онд хэвлүүлсэн “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь: түүх-угсаатны зүйн туршиц судалгаа” бол Монголын угсаатан зүй, генетикийн судлалд томоохон түлхэц болсон бүтээл юм. Мөн монголын Хэл, утга зохиолын хүрээлэнд нэрт эрдэмтэн Б.Ринчен ажиллаж байсан бөгөөд түүний ажил үүргийн тодорхойлолтонд “хэл, ардын аман зохиол, угсаатан зүйн” судлаач хэмээн дурьдсан байдаг. Бид Б.Ринченгийн угсаатан зүйн судалгааны талаар дараа нь авч үзнэ.

С.Бадамхатан эргэж ирснээр Монголын мэргэжлийн угсаатны зүйн судлал жинхэнэ эхэлсэн юм. Бусад археологич, түүхч, яруу найрагч зэрэг хүмүүсээс ялгаатай нь С.Бадамхатан зөвхөн угсаатны зүйн судлалаар дагнан ажилласан. 1963 онд энэ салбарт өөр нэгэн угсаатны зүйч болох Гэлэгжамцын Цэрэнханд Москвагийн их сургуулийг уг мэргэжлээр төгссөн ирснээр салбар улам бүр бэхэжсэн байна. 1966 онд мөн л Москвагийн Их сургуулийг угсаатны зүйч мэргэжлээр төгссөн Гончигийн Батнасан тэдний эгнээнд нэгдэн оров. 1967 онд Бадамхатан Москвагийн Их Сургуульд Угсаатны зүйн судлалаар кандидатын зэрэг (докторын зэрэгтэй адил), Цэрэнханд 1976 онд Ленинградын Угсаатны зүйн хүрээлэнд кандидатын зэрэг тус тус хамгаалжээ.

С.Бадамхатан өөрийн ажлаа орон нутгийн угсаатны зүйн судалгааг бэхжүүлэх зорилгоор 1958 онд “Этнологийн судалгаа хийх арга барилын тухай” хэмээх бүтээлээр ажлаа эхлүүлжээ. Энэ нь аймгуудын орон нутгийг судлах кабинетын судлаачдад зориулсан гарын авлага байсан бөгөөд аймаг бүрийн ястнуудын соёл, амьдралын хэв маягийн талаар материал цуглуулахыг зөвлөж, яваандаа уг кабинетуудыг угсаатны зүйн тасаг болгохыг зорьж байсан аж.

1957 оноос эхлэн Түүхийн тасгаас Ховд, Увс, Чойбалсан, Булган, Хөвсгөл аймгууд руу Дөрвөд, Захчин, Торгууд, Алтайн Урианхай, Мянгад, Буриад, Халх, Дархад ястнууд болон Цаатан ардын гарал үүсэл, эдийн болон оюуны соёл, бөө мөргөлийн талаар судалгаа явуулж, материал цуглуулах хээрийн судалгаануудыг зохион байгуулав. Эдгээр үйл ажиллагааг ахлан зохион байгуулсан гол хүн нь С.Бадамхатан байсан бөгөөд гол анхаарлаа Хөвсгөлийн Цаатан болон Дархадуудад хандуулж, жил бүр 2-4 сарын хугацаанд экспедицээр явдаг байв.



Судалгааны ажилдаа үндэслэн тэрээр 1962 онд “*Хөвсгөлийн Цаатан ардын аж байдлын тойм*” хэмээх нэг сэдэвт зохиол бичжээ. 1965 онд “*Хөвсгөлийн Дархад ястан*” хэмээх хоёр дахь номоо гаргасан нь 1967 оны кандидатын ажлынх нь суурь болж өгсөн байна.

С.Бадамхатан угсаатны зүйн судалгаандаа угсаатны түүх, аж ахуй, эдийн болон оюуны соёл, шашин гэсэн таван чиглэлийг хамарсан нь Монголын угсаатны зүйн зохиолд одоо ч ноёлж байгаа Зөвлөлтийн угсаатны зүйгээс гаралтай юм. Энэ үед түүний гол сонирхол *ястан* гэж тодорхойлдог Дархадын өвөрмөц талуудыг баримтжуулах байлаа. Мөн Дархад, Цаатны бөө мөргөлд онцгой анхаарал хандуулж байсан нь мухар сүсэг гэж хязгаарлалгүй харин Дархад, Цаатан ардууд бөө мөргөлийн анхны хэлбэрийг хэвээр хадгалж чадсан учраас түүнийг судлах нь “эртний бөө мөргөл, шүтлэгийн талаарх олон асуултад хариулт олох чухал хэрэгтэй” (Бадамхатан 1962: 73) гэж үзсэнийх юм.

1960-аад оны эхэн үеэс шинэчлэгдэн зохион байгуулагдсан Шинжлэх Ухааны Академийн угсаатны зүйчдэд 1959 онд МАХН-аас гаргасан нэгдэлжих хөдөлгөөнийн бүрэн ялалт, улмаар социалист харилцаа улс орны хөгжил, дэвшилтэд хэрхэн яаж нөлөөлснийг болон социалист “шинэ хүн” бий болох явцыг судлах ажил өгчээ. Нэгдэлжих хөдөлгөөн ялсан нь малчин ардын хувийн өмчийг хураах үйл явцтай холбоотой байлаа. 1960-аас 1980-аад он хүртэл угсаатны зүйчид нэгдэлчин малчдын амьдралын шинэ хэлбэр, угсаатны үйл явц, монголын социалист амьдралын хэв маягийг судлах ажил хийж байлаа. Тухайлбал Г.Цэрэнханд 1964 онд Архангай аймгийн Чулуут, Тариат сумууд руу экспедиц хийж, гурван асуудлыг судалсан нь: 1. Угсаатны бүлгийн онцлог, түүхэн хөгжил, оршин сууж буй газар нутаг 2. Ардын хувсгалын жилүүдэд малчдын амьдрал, оюун санаанд гарсан өөрчлөлт 3. Хувьсгалын жилүүдэд малчдын шинээр үйлдвэрлэсэн материаллаг зүйлс болно (Цэрэнханд 1965 [2005]: 206). Энэ судалгаа нь 1972 онд “*Хөдөө аж ахуйн нэгдэлчдийн өрх гэр, гэр ахуй*” хэмээх нэг сэдэвт бүтээл болон хэвлэгджээ.

1970-аад оноос Г.Цэрэнханд гол төлөв монгол малчдын социалист төлөвшил болон малчдын сэтгэл зүйд нэгдэлжүүлэлтэд хамрагдсан явдал хэрхэн нөлөөлсөн тухай судалгаануудыг хийж байв. Малчин айл өрхүүдэд гарсан өөрчлөлтийн талаар голлон анхаарсан байна. Хамгийн том өөрчлөлт нь өрх гэрт эзлэх эмэгтэйчүүдийн байр суурь эрчүүдийнхтэй ижилдүү болсон явдал байв. Мөн Г.Цэрэнханд эмэгтэйчүүд хүйсээс бус ур чадвараасаа шалтгаалан өрх толгойлох нь ихэсж байгааг дурьджээ. Энэ мэдээ нь ихэд сайшаагдсаны учир нь хүйсийн тэгш байдал нь эмэгтэйчүүд ёс заншил, шашны бүх төрлийн шахалтаас гарч, социалист бүтээн байгуулалтын ажилд хувь нэмрээ оруулж байна гэсэн утгыг агуулж байсан юм. Тэрээр 1981 онд уг судалгаагаа “*Нэгдэлч малчдын аж байдал*” хэмээх нэг сэдэвт бүтээлдээ нийтлүүлжээ.

Монголын угсаатны зүйчид шинэ хэв маягийн амьдралыг зүгээр нэг магтан дуулаад суусангүй. Үнэндээ тэд нийгмийн өөрчлөлтийн томоохон “үйл явцыг” баримтжуулж байсан билээ. Тэд МАХН-д Монголын шинэ социалист зан үйл,

бэлгэдлийг бий болгоход тодорхой хэмжээнд тусалж байсан юм. Жишээлбэл Г.Цэрэнханд өөрийн судалгааны ажилдаа МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэнгийн Монгол улсын тэргүүний суртал нэвтрүүлэгч ухуулагчдын II зөвлөлгөөн дээр хэлсэн үгнээс эш татан ашигласан байна. Манайд насны ой тэмдэглэх, гэрлэх, сайшаал шагнал хүртэх, сургууль төгсч мэргэжил боловсрол эзэмших зэрэг хүмүүсийн амьдралын зан үйл нь тогтсон журам горимгүй урсгалаараа явагдаж байна. Эдгээр хүний амьдралд тохиолдох онцгой үйл явдлуудыг зөв тэмдэглэх нь ард иргэдэд, ялангуяа залуу үеийнхэнд онцгой чухал учир үндэсний уламжлалыг хадгалж, түүнийг шинэлэг зүйлсээр баяжуулж байх нь зүйтэй юм (Цэрэнханд 1972 [2005]: 20). Намын удирдлагын энэ мэт үгс нь угсаатны зүйчдэд эртний ёс заншлыг саадгүйгээр судлахад тус болж байсан хэдий ч манай судлаачид аливаа зүйлст авах-гээхийн ёсоор хандаж байсан юм.

Энэ цаг үед хийгдсэн ихэнх судалгааны ажил нь халхчуудыг хамарч байлаа. Г.Цэрэнхандын судалгаанууд хуучнаар Сайн ноён хан аймаг буюу халхуудын төв нутаг Архангай, Өвөрхангай аймгуудад явагдаж байв. Монголын угсаатны зүй анхандаа үндэстний цөөнхийг хамарч байгаад халхад төвлөрөх болсон нь хачирхалтай юм. 1962 онд С.Бадамхатан Халхад явуулах угсаатны зүйн судалгааг эрчимжүүлэх хэрэгтэй гэж бичиж байжээ (Бадамхатан 1962: 73). Түүний саналыг Монголын сэхээтний хүрээнд өргөцөөр дэмжиж, тэргүүний түүхчид Халхад анхаарлаа хандуулах болсон байна. Жишээлбэл, 1962 оноос хойш 30 жилийн турш Түүхийн хүрээлэнг тэргүүлсэн академич Ш.Нацагдорж 1963 онд өөрийн “Халхын түүх” хэмээх номыг хэвлүүлсэн байна. Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Гонгор “Халх товчоон” хэмээх хоёр боть номыг 1970, 1978 онуудад хэвлүүлсэн байна. 1967 онд С.Бадамхатан Москвад дэд эрдэмтний зэрэг хамгаалж ирээд халхад гол анхаарлаа хандуулсанд гайхах зүйлгүй бөгөөд 1972 онд “Боржигин Халх” хэмээх нийтлэлийг хэвлүүлжээ. Ингэж Халхад төвлөрөх болсон нь үнэндээ социалист үндэстэн бүтээн байгуулах томоохон ажлын хэсэг байв. Дээр дурьдсанчлан 1960-аад оны эхээс өмнө угсаатны зүйчид гол анхаарлаа бага ястнуудын үүсэл гарал, эдийн болон утга соёлд хандуулж байсан. Харин 1970-аад оны үеэс, тэд Зөвлөлтийн угсаатны зүйч Ю.Бромлейгийн боловсруулсан онолыг дагаж, нэгдсэн социалист Монгол үндэстэн бүрдэх, “угсаатны үйл явцыг” тодорхойлох болов. С.Бадамхатан 1982 онд хэвлүүлсэн онолын бүтээлдээ монгол “угсаатны үйл явцыг” жагсаан харуулахыг оролдсон байна. Уг бүтээлдээ *ethnos* гэдгийг монгол хэлнээ угсаатан хэмээн хөрвүүлж, эртний Монгол *овог аймгууд* нийлээд *угсаатныг* бүрдүүлнэ гэсэн нь ерөнхийдөө биологийн тодорхойлолт бөгөөд одоо ч гэсэн хэрэглэгдэж байна. Түүний бичсэнээр:

*Үндэстэн* түүхэн цаг үед, тухайлбал капиталист нийгэм феодалын нийгмийг устгах үед бий болсон. Харин нөгөө талаас *Угсаатан* нь феодалын үед үүсэл гарлаараа нэгдэж, нийгмийн хөгжлийн үе шатуудад *аймаг*, *ястан* гэдэг нэрээр оршин тогтнож ирсэн хүмүүс юм. Социализмын цаг үед, нийгмийн өөрчлөлт хөгжлийн үр нөлөөгөөр *ястан* болон *угсаатны* аж ахуй соёлын өөрчлөлт нь шинэ нэгдэл болох социалист *үндэстнийг* бий болгосон (Бадамхатан 1982: 9) гэжээ.

Энэ нь бусад цөөнх *ястнууд* С.Бадамхатангийн нэрлэснээр “Монгол *үндэстний* цөм бүлэг болох Халхын хэл, соёл, уран зохиолд тулгуурласан нийгэм улс төрийн нэгжид” (мөн тэнд. 10) нэгдэхийн тулд өөрийн ижилслийг орхисноор социалист монгол *үндэстэн* бүрэлдэн бий болно гэсэн үг юм.

Ингэж Халхад төвлөрсөн социалист Монгол *үндэстэн* бүрэлдэх угсаатны үйл явцаар тайлбарлах нь С. Бадамхатан 1972-1977 оны хооронд Монголын Залуучуудын Эвлэлийн Төв Хорооны хоёрдугаар ерөнхий нарийн бичгийн даргаар хэсэг ажиллаж байгаад 1978 оноос эргээд Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн тасгийн эрхлэгч болсон үеэс Түүхийн Хүрээлэнгийн гол зорилго болжээ. Дээрх зорилгоор 1980 онд Хүрээлэнд Ленинградын Үйлдвэрлэл, Урлалын дээд сургуулийг төгсгөсөн урлан бүтээгч Төмөрбаатарын Дисан, Ленинградын Их Сургуулийн угсаатны зүйн ангийн төгсөгч Дугарын Нансалмаа нарыг судлаачаар ажилд авсан байна. Эдгээр шинэ судлаачид С.Бадамхатангийн санаачлага удирдлагаар 1981 онд эхэлсэн гурван боть номыг хамтран бичжээ. Эхнийх нь 1987 онд хэвлэгдсэн *Халхын угсаатны зүй* хэмээх боть юм (хян. Бадамхатан 1987). Нэгдүгээр ботийн удиртгалд С.Бадамхатан Халхыг сонгосон шалтгаанаа тайлбарлахдаа “Халх ястан нь Монгол олон овогтон, угсаатны нэг гол хэсэг, Монголын ард түмний түүхэнд ялангуяа XIV зууны хоёрдугаар хагас үеэс феодалын нийгмийн үеийн олон монгол ястан бүрэлдэн тогтох үйл явцад онцгой байр суурь гүйцэтгэж ирсэн ба Халх ястны соёл нь нийт монгол овогтны соёлын цогцолборын нийллэг, гол мөхлөг нь тул Халхын угсаатны зүйг судлах учир холбогдол үүнд оршино” гэжээ (хян. Бадамхатан 1987: 6).

С.Бадамхатан Халхыг ястан гэсэн нь Халхад ямар нэг “угсаатны” тодорхойлолт өгөөгүй Ш.Нацагдорж болон Д.Гонгор нараас ялгаатай байгаа юм. Д.Гонгор Халхыг 8-р зуунд үүссэн гэж тогтоосон бол С.Бадамхатан 16-р зууны дунд үед бий болсон “Халхын Хаант” улс нь халх ястны үүсэл болсон гээд феодалын үеийн угсаатны бүх шинжийг хадгалсан ястан болох үйл явц нь 17-20-р зууны үед байсан гэж бичсэн (мөн тэнд. 48). Өөрөөр хэлбэл С.Бадамхатангийн тодорхойлсноор Халх ястан нь Монголын олон түүхчдийн ойлгодог шиг овог бус, харин олон жижиг овгуудын нэгдэл байсан юм. Мөн түүний хэлснээр Халх нь өөрийн гэсэн газар нутаг, засаг захиргаатай улс төрийн нэгдэл байсан учраас БНМАУ-ын харьяан дахь бусад овгуудыг өөртөө уусган социалист Монгол *үндэстнийг* бий болгосон ажээ.

Уг боть нь товчхондоо Халхын соёлын өвийг устгалгүй, хойч үедээ өвлүүлэн 20-р зуунд авчирсан түүх угсаатны зүйг магтан дуулсан хэрэг байсан юм. Энэхүү мэдлэгийг олж авснаар Монголчууд өөрсдийн соёлыг хөгжүүлэх итгэл төрж, мөн бусад *үндэстний* “дэвшилтэт” соёлыг хүндэтгэн хүлээн авч дэлхий дахины эв санааны нэгдлээс хоцрохгүй байх ач холбогдолтой гэж С.Бадамхатан тэмдэглэсэн байна. “Дэвшилтэт” соёл нь зөвхөн танин мэдэхүйн бус, амьдралд сайнаар хэрэглэх бүрэн боломжтой. Тухайлбал, уламжлалт ураг төрлийн ёс журам нь “хамаатнууд хоорондоо цусан төрлөө сайн мэдэж, дагаж байх ач холбогдолтой” (хян. Бадамхатан 1987: 411).

Хүрээлэнгийн тэргүүлэх угсаатны зүйчдийн 20 жилийн турш цуглуулсан мэдээлэл болон 1981-1984 оны хооронд I ботид тусгайлан зориулж цуглуулсан хээрийн судалгааны мэдээ зэргийг харгалзан номыг дөрвөн бүлэгт хуваасан: угсаатны гарал үүсэл, аж ахуй (мал аж ахуй, ан агнуур болон хөдөө аж ахуй, тээвэр, нийгэм болон суурьшил), эдийн соёл (орон байр, хувцас, хоол, гар урлал), оюуны соёл (гэрлэлт, гэрлэх ёслол, гэр ахуй, ардын зан заншил, мэдлэг, билэгдэл, ардын хөгжим, тоглоом, наадам, уламжлалт шүтлэг). Судлаачид 500 гаруй асуулт бэлтгэж, тэдгээрийгээ сэдвээр нь хуваарилан авсан байна. Хээрийн судалгааны ажил 1930-аад оны үед хэрэглэхээ больсон халхын доторхи нэршил болох Хатагин, Урианхай, Илжгин, Олхонуд, Хариад овгуудын мөрөөр хоёр сумд ажиллажээ.

Хоёр болон гуравдугаар ботиуд есөн жилийн дараа буюу 1996 онд хэвлэгджээ. Анхандаа хоёрдугаар боть Ойрадуудын тухай, гуравдугаар боть Хасагуудын тухай байхаар төлөвлөж байв. Гэвч хэвлэгдэх үедээ гуравдугаар боть нь Буриад, Барга, Үзэмчин, Дариганга, Тува, Хотон зэрэг Халх, Ойрад бус аймгуудыг багтаасан байна. Хасагуудын тухай бүлэг одоо болтол хэвлэгдээгүй байна.

1997 онд Монголын угсаатны зүйн гурвалсан бүтээл Соёлын Яамны оны шилдэг номоор шалгарсан юм. Олон жилийн судалгааны ажлын үр дүнд уг номд 19-р зууны сүүл үе болон 20-р зууны эхэн үеийн Монгол овогтнуудын ахуй амьдрал, соёлыг тэмдэглэн үлдээсэн нь өдгөө Монголчуудын биет бус өв болжээ. Монголын шилдэг угсаатны зүйчдийн бичсэн энэ гурван боть Монголын шинжлэх ухааны түүхэнд томоохон орон зайг эзэлж байна.

## **Б. Ринчен ба “Угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас”**

Бүх угсаатны зүйчид Түүхийн хүрээлэнгийн харьяалалд байсангүй. Ж.Цэвээний хамт Монголын угсаатны зүйг үндэслэсэн Б.Ринчен Хэл, уран зохиолын хүрээлэнд ажиллаж байлаа. 1963 онд Б.Ринчен монголын буриадуудын нутгийн аялгуу, угсаатны зүйг судлах судалгааны багийг ахлав. Энэхүү судалгаанаас гарсан гол бүтээлүүд нь Б.Сумъяабаатарын 1966 онд хэвлүүлсэн “Буриадын угийн бичээс”, мөн Б. Ринченгийн 1968 онд хэвлүүлсэн “Монгол Ард Улсын Хамниган аялгуу” номууд юм.

1960-аад оны агуу амжилтуудын нэг нь 1969 онд бүтээж, 1979 онд нийтийн хүртээл болсон “Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас” хэмээх 2 боть ном билээ. Уг атласыг бүтээхэд олон хэл шинжээч, түүхч, газарзүйч хувь нэмрээ оруулж, Б.Ринчен хянан тохиолдуулсан байна. Түүхийн Хүрээлэнгээс нэг ч угсаатны зүйч оролцоогүй юм.

Атласын эхний боть нь 2 хэсэгтэй. Эхний хэсэг нь номыг бэлэн болох хүртэл буюу 1921-ээс 1970 оны хооронд Судар Бичгийн Хүрээлэн болон түүний залгамж байгууллагуудын удирдлага дор гадаад, дотоодын эрдэмтдийн хийсэн хээрийн судалгааны экспедиц, мэдээллийн эх сурвалжуудын байршлыг тэмдэглэжээ. Хоёрдугаар хэсэг нь дараах зүйлсийг багтаасан “угсаатны зүйн судалгаа” байсан.

Үүнд: Хүн гүрнээс Монгол Ард Улс хүртэлх засаг захиргааны нэгжүүд, сүм дуганууд, овог, өдөр тутмын бүтээгдэхүүн, зэрлэг жимс ногоо, хөдөө аж ахуй, монгол гэр, тээврийн хэрэгсэл, бичгийн дурсгал, дөрвөлжин, тод болон араб үсгийн тархалт, мөн үлгэр туульсын тархалт. Хоёрдугаар боть нь Монгол хэл, түүний авианы (эгшиг гийгүүлэгч) төрлүүд болон тэдгээрийн тархалтын атлас юм.

Анхны хэвлэлд уйгар, дөрвөлжин, тод, соёмбо үсэг болон тэдгээрийн латин галиг зэрэг “Монголын ард түмний хэл соёлын баялаг өвийг судлагч багш, эрдэмтэд дэмжлэг болох” маш их мэдээлэл агуулагдаж байжээ (хян. Ринчен 1979: 8). Гэвч 1979 оны хэвлэлтэд дээрх хэсэг болон атласт мэдээлэл өгсөн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хассан байна. Уг нэрсийн жагсаалтыг оруулах гол зорилго нь төслийн өргөн цар хүрээ, эх оронч үзэл, монголчуудын соёлын өвөө хадгалах хүсэл эрмэлзлийг харуулах байсан юм.

Монголын олон бүлгүүд хала, эцэг, элигэн, отог, яс зэргээр нэрлэдэг “овог” гэдэг нэрийг тайлбарласан нь сонирхолтой юм. Б.Ринченгийн хэлснээр *Монголын Нууц Товчоон*д гарч байсан эртний овгуудын нэрс өдийг хүртэл хадгалагдан ирсэн байна. Тэдгээр нэрсийн зарим нь номд дурьдагдсан газраа хэвээр байсан бол зарим нь өөр газраас олдсон нь “угсаатны гарал үүсэл, хэл соёл, түүх судлаачдад олон асуултыг гаргаж тавьсан” (мөн тэнд. 9).

Уг *Атлас* үнэхээр хосгүй бүтээл мөн. Монголын угсаатны зүй, хэл шинжлэлийн ялгаатай шинжийг газрын зургаар харуулж чадсан энэхүү бүтээл нь урьд нь хэвлэгдсэн ном бүтээл, 1921-1970 оны хооронд хийгдсэн хээрийн судалгаа, мөн хамгийн чухал нь Монгол улс даяар суугаа хувь хүмүүс гэсэн гурван эх сурвалжид үндэслэсэн байна. 1967 оны 1 сарын 9-нд Б.Ринчен *Үнэн* сонинд “Олны тусламжаар бүтэх атлас” хэмээх Монголын ард түмэн, багш сурагчид, сайн дурынханд зориулсан 2 асуулт бүхий нийтлэлийг хэвлүүлсэн нь: “1. Танай суманд ямар овог яс байдаг вэ?” “2. Танай суманд хүмүүс энэ тухай ямар үлгэр домог ярьдаг вэ?” гэсэн асуулттай байв. Уг нийтлэлдээ ийм мэдээллийг яаж цуглуулах зааврыг нь өгсөн байна. Мөн дараа нь *Утга Зохиол*, *Урлаг* (1967 оны 3 сарын 24), *Хөдөлмөр* (1967 оны 4 сарын 4), *Үнэн* (1968 оны 3 сарын 21), *Залуучуудын үнэн* (1968), *Хөдөлмөр* (1968 оны 12 сарын 12) сонингуудад сүм хийд, цагаан идээ зэрэг бусад зүйлсийн талаар асуултуудаа нийтлүүлжээ. Дээрх бүх нийтлэлдээ Б.Ринчен судалгаа өгөгсдийн нэрийг хавсралтад оруулна гэж амлаж, уг бүтээлийн өргөн цар хүрээ, эх оронч үзлийг харуулахыг зорьсон байна.

Гэвч уг төсөл удалгүй орон нутгийн холбогдох мэргэжлийн судлаачдын эсэргүүцэлтэй тулгарсан байна. “*Үнэн*” (1968 оны 3 сарын 21) сонинд хэвлүүлсэн уриалгадаа Б.Ринчен:

Хэдийгээр бүх сумдуудад орон нутгийн талаар судлах музей болон тусгай тасгууд байдаг хэдий ч одоог хүртэл тэднээс нэг ч материал ирээгүй байна. Орон нутгийг судлах үүрэгтэй хүмүүс Шинжлэх Ухааны Хүрээлэнд маш чухал хэрэгцээтэй мэдээллийн хүсэлтэд хариулахгүй байгаа нь ойлгомжгүй юм. Энэ бүхэн үнэхээр гайхал төрүүлэм байгаа бөгөөд Соёлын яам энэ талаар тодорхой

арга хэмжээ авч, тэрхүү музей болон тасгийн эрхлэгчдэд орон нутгийн судлал болон шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулах ёстойг нь сануулна гэдэгт итгэж байна (Ринчен 2002: 233–34) гэж бичжээ.

Дээр дурдсанчлан орон нутгийн судалгааны тасгууд Түүхийн хүрээлэнд мэдээлэл өгч байсан учраас ийнхүү хариу өгөхгүй байсан нь хоёр хүрээлэнгийн өрсөлдөөнөөс үүдсэн эсэх нь тодорхойгүй байна. Мөн Соёлын яамнаас ямар нэгэн шахалт үзүүлсэн эсэх нь тодорхой бус юм. Гэхдээ уг *Атлас*-ын ихэнхи мэдээлэл нь сүм дуганаас эхлээд домог туульсын овгийн нэр хүртлэх “феодалын” гэгддэг сэдэвтэй холбосныг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь энэ үед Монгол улс Түүхийн хүрээлэнгийн судалснаар капитализмыг алгасан социалист Монгол улс байгуулах үе шатандаа явж байсан юм.

Б.Ринченгийн нэлээдгүй анхаарал хандуулсан, магадгүй ажлын нь гол учир шалтгаан болсон нэг асуудал бол монгол гэр бүлийн тухай юм. Атласыг бүтээх болсон Б. Ринченгийн зорилго “*Залуу үе*” (дуг.4, 1968) сэтгүүлд хэвлүүлсэн “Ураг төрлийн учир” хэмээх нийтлэлээс харагдаж байлаа. Уг нийтлэлд тэрээр Монголын ураг төрлийн тогтолцоонд гарч буй хямралын талаар бичсэн юм. Үүний нэг тод жишээ нь *хүүхэн* гэдэг үг насанд хүрсэн болон гэрлэсэн эмэгтэйчүүдийг илэрхийлдэг болсон явдал юм. Түүний хэлж буйгаар Их хүрээ буюу одоогийн Улаанбаатарт байсан лам нар болон хятад худалдаачид биеэ үнэлэгчдийг *янхан* буюу зөөлрүүлэн *хүүхэн* гэж дууддаг байжээ. Нийслэл хотод лам нар болон худалдаачдын байр суурь илүү өндөрт байсан учир “энгийн ардууд тэднийг дуурайж өөрсдийн эхнэрээ *хүүхэн* гэж дуудах болж, улмаар хүмүүс тэрний *хүүхэн*, энэний *хүүхэн* гэх мэтээр ярих болсон байна” (Ринчен 1968 [2002]: 238). Мөн цаашлаад олон хүүхдүүд эцгээ мэддэггүй байснаас ураг төрлийн асуудал ихээр үүсэх болсон гэж бичжээ. Иймээс Б.Ринченгийн угсаатны зүйн судалгааны зорилго нь ураг төрлийн ёс заншлууд, тэр дундаа овгийн тогтолцоог сэргээх явдал байсан юм. Түүний бичсэнээр:

Хүн төрөлхтөнд байдаг ураг төрлийн зохион байгуулалтыг оросоор этнология гэх бөгөөд энэ нь Грекийн *ethnos* буюу угсаатан *logos* буюу судлал гэсэн үгсээс гаралтай. Уг нийлмэл үгийг Мозин гэдэг эрдэмтэн бий болгосон бөгөөд Монголоор энэ нь нийлмэл үгийн дүрмээр *угсаатны судлал* болно. Дээрх номлолын дагуу гэрлэлтийг эндогам болон экзогам гэж 2 ангилна (мөн тэнд. 239).

Энд угсаатны зүй зөвхөн ураг төрлийн ёс журмын тухай ярьдаг эсэх нь биш Б.Ринчен тийм үзэл бодолтой байсан нь чухал юм. Овгийн нэрийг гээх болсон нь “Манжийн дарангуйлагчдын далд бодлогын нэг хэлбэр бөгөөд тэд монголчуудыг овгийн нэрний оронд хошууны нэр хэрэглэдэг болгосон. Ингэснээр Монголчууд яс, мах гэсэн ялгааг мартаад зогсохгүй түүнээс ноцтой нь цус ойртох нь ихсэх болсон” гэжээ. Түүний хэлснээр эрт цагт монголчууд ураг төрөлтэй холбоотой өвчнүүдийн талаар маш сайн мэдлэгтэй байсан байна. Энэ нь орчин цагийн анагаах ухаантай нэгэн түвшинд байсны илрэл гэжээ.

## Монголын угсаатны зүйн буурал ба сэргэн мандал

Орчин үеийн монголын түүхэнд 1990-ээд оны үе бол Монгол улс далан жилийн коммунист засаглалыг халж, ардчилсан улс болсон онцгой он жилүүд юм. Гэвч Түүхийн хүрээлэнгийн монголын угсаатны зүйн судлалын тасгийн хувьд ихээхэн гарз хохирлын үе байлаа. 1991 оноос Нансалмаа Монголын Үндэсний түүхийн музейд ажиллах болж, 1998 оноос Г.Батнасан хувийн сургуульд багшлах болжээ. С.Бадамхатан 1998 онд өөд болов. Угсаатны зүйн тасаг 1996 онд Монголын угсаатны зүйн 2, 3-р боть хэвлүүлэх зорилгодоо хүрч, дараа жил нь шилдэг номын шагнал хүртсэн байна.

1990-ээд оны үед гол хөдөлгөгч хүч нь монголын шинэ зан үйлээр мэргэжлээ сольсон Хандын Нямбуу хэмээх Монгол хэл уран зохиолын мэргэжилтэн байлаа. Тэрээр Б. Ринченгийн Атласын төсөлд оролцсон бөгөөд 1969-1972 оны Түүхийн хүрээлэнд ажиллаж байв. 1985-1989 оны хооронд Ховд аймгийн Багшийн коллежид багшилсны дараа тэрээр Монгол Улсын Их Сургуульд багшлах болж, улмаар Нийгмийн Шинжлэх Ухааны сургуулийн Түүхийн тэнхимийн дэргэд Угсаатны зүйн тэнхим байгуулсан байна. 1995 онд уг тэнхим түүхийн тэнхимээс зарим оюутныг авч тусдаа тэнхим болсон бөгөөд 1997 оны намраас шинэхэн оюутнуудаа элсүүлж эхэлжээ.

Гэвч 1998 онд Х.Нямбуу цаг бусаар өөд болсноор тэнхим эзэнгүй үлдсэн. Уг тэнхимд Дэлхийн ард түмнүүдийн угсаатны зүйн хичээл орж байсан Г.Цэрэнханд, С.Бадамхатанг өнгөрснөөс хойш Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн секторыг эрхэлж байгаад 1998 оноос тэнхимийн эрхлэгчээр давхар ажиллах болов. Дараагийн найман жилд тэрээр ихээхэн хүчин чармайлт гарган шинэ тэнхимийг Москвагийн их сургуулийн загвараар Оросын угсаатны зүйн хичээлийн хөтөлбөрт нийцүүлэн зохион байгуулсан байна. Шинээр нэмэгдсэн хичээлүүд нь: Дэлхийн ард түмнүүдийн угсаатны зүй, Угсаатан судлалын онол сэтгэлгээний түүх, Дэлхийн шашин, Ази-Сибирийн угсаатны зүй, Эд өлгийн соёл, Монголын шашны зан үйл, Монголын угсаатны зүй, Сэтгэл зүйн түүх, Музей судлал болон Угсаатны хүн ам зүй зэрэг байлаа.

2006 онд проф. Г.Цэрэнханд эрхлэгчийн ажлаа өгсний дараа Японы Хоккайдо их сургуулийн төгсөгч, нийгмийн антропологич Л.Мөнх-Эрдэнэ тэнхимийн эрхлэгчээр ажиллах болсноор шинэчлэлийн бас нэгэн үе эхэлжээ. Тэнхимийн нэрийг Нийгэм Соёлын Антропологийн Тэнхим болгон өөрчилж, Их Британий нийгмийн антропологид суурилсан шинэ сургалтын хөтөлбөр нэвтрүүлэв. Кэмбрижийн их сургуулийн Монгол ба дотоод ази судлалын төв (MIASU)-тэй хамтран ажиллах болж, докторын дөрвөн оюутандаа дэмжлэг үзүүлж байна. Одоо тэнхимийн эрхлэгчээр Кэмбрижийн их сургуульд нийгмийн антропологоор докторын зэрэг хамгаалсан Д.Бум-Очир ажиллаж байна.

Олон жил завсардсаны дараа 2004 онд Түүхийн хүрээлэнгийн угсаатны зүйн сектор Москвагийн боловсролын их сургуульд докторын зэрэг хамгаалсан, түүхэн угсаатны зүйч С.Чулууны удирдлага дор шинэчлэгдэж эхлэв. 2010 онд

секторыг нэрийг өөрчлөн, Угсаатан судлал, нийгэм-соёлын хүн судлалын салбар болгож, шинэ хээрийн судалгаануудыг эхлүүлж байна. Тус хүрээлэн мөн МДАСТ (MIASU)-тай гэрээ байгуулжээ.

Өөрчлөн шинэчлэгдсэн Монгол Улсын Их Сургууль болон Шинжлэх Ухааны Академи дахь тэнхим салбарууд шинэ шинэ хүн судлалын судалгаанууд явуулах нь дамжиггүй бөгөөд энэхүү оршлоо Шинжлэх Ухааны Академийн ахмад угсаатны зүйч Г.Цэрэнханд, Л.Билэгт нарын сонирхолтой мэтгэлцээнээр өндөрлүүлэе.

Б.Ринченгийн овгийн нэрийг ургийн овог болгох хүсэл нь 1990-ээд оны үед Улсын Их Хурлаас хүн бүр ургийн овогтой болж иргэний үнэмлэх дээр бичүүлэх хууль баталснаар биеллээ олсон байна. 1991-2001 оны хооронд Түүхийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан түүхч, археологич, овгийн нэрийг сэргээхийг тууштай дэмжсэн А. Очир, Ж.Сэржээгийн хамтаар 1993 онд “Хэнтий аймгийнхний овгийн товч лавлах, угийн бичиг сэргээх зөвлөмж” хэмээх бяцхан ном, 1996 онд “Монголчуудын овгийн лавлах” хэмээх Монгол дахь олон зуун эртний овгуудын нэрийг багтаасан ном гаргасан байна. Эдгээр нь монголчуудад овгоо тогтоох гарын авлага болж өгчээ.

Л.Билэгт болон Г.Цэрэнханд нар А. Очирын овог хэмээх тодорхойлолтыг зохих хэмжээнд эсэргүүцэж байгаа юм. 2003 онд хэвлүүлсэн “ ‘Овог’ хэмээх нэр томъёоны орчин үеийн ойлголтыг судалсан урьдчилсан дүнгээс” хэмээх хамтарсан нийтлэлдээ (Цэрэнханд, Билэгт 2003 [2005]) тэд Монголын эрдэмтэд Оросын алдарт монголч эрдэмтэн Борис Владимирцовын 1934 онд хэвлүүлсэн “Монголчуудын нийгмийн бүтэц: Монголын нүүдэлчдийн феодализм” хэмээх номдоо 11-12 дугаар зууны үед *овог* гэдэг нь нэгэн ураг төрөл бүхий нийгмийн байгууллын нэгж гэсэн буруу тодорхойлолтыг ашигласан гэж бичжээ. Тэдний хэлж буйгаар “*овог*” гэдэг нь тухайн үеийн нүүдэлч малчдын нийгмийн байгууллын нэгжийн нэр болохоос биш угсаа гарал, ураг төрлийн нэр биш, “*фамилия*”, “*surname*” гэдгээс ч өөр гээд, түүний гарал үүсэл хэрэглээ нь зөвхөн хүний нэр биш, хэн нэгний нийгмийн харилцаанд оролцох нэрийг тодотгох нэршил байсан гэжээ (мөн тэнд: 140). Тэдний үзэж буйгаар 13 дугаар зуунд Их монгол улс байгуулагдсаны дараа монгол малчдад овог байгаагүй учир саяхны овгийг сэргээх оролдлого нь баталгаатай бус онолын эх сурвалжид үндэслэсэн гэж үзэж буй юм. Нийтлэлд Хэнтий аймаг дахь бүр 1918 оны үед төрсөн халх монголчуудын ярилцлагыг нийтэлсэн байна. 1993 оны А.Очир, Ж.Сэржээ нарын номон дахь овгийн нэрнээс асуухад тэдгээр нэрсийг залууд нь хэрэглэж байсныг огт санахгүй байв. Тэд овгийн нэрний тухай ном сонингоос л мэдэж авсан байлаа.

Л.Билэгт, Г.Цэрэнханд нарын судалгаа нь өөр судлаачдын ажлыг үгүйсгэж байгаадаа бус, харин Монголын угсаатны зүйд тулгамдаад буй нийгэм, улс төрийн ач холбогдолтой асуудлаар мэтгэлцэж байгаагаараа онцлог юм. Энэ мэт эрдэм шинжилгээний мэтгэлцээнийг өдөөж цаашид судалгаа явуулах хэрэгтэй. Яг иймэрхүү маргаан мэтгэлцээний дүнд угсаатны зүйчид болон антропологичид нэгдсэн нэг байр суурьт хүрч чадсанаар Монголд шүүмжлэлт эрдэм шинжилгээний салбарыг хөгжүүлэх болно.



## Ашигласан ном, бүтээлүүд

- С.Бадамхатан  
1958. “Этнографийн судалгаа хийх арга барилын тухай”. Улаанбаатар: Шинжлэх Ухаан, Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл.  
1962. “Монгол орны угсаатны зүйн судлалын байдлаас”. *Студиа Хисторика*, 2.  
1965. [2005]. “Хөвсгөлийн дархад ястан”. Улаанбаатар: Соёмбо.  
1972. “Боржгин халх”, *Этнографийн судлал*, 4.  
1987. (хян.) “Халхын угсаатны зүй”. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар. Урадын Э. Булаг.  
1998. “Монгол дахь үндсэрхэх үзэл ба эрлийзжилт” (*Nationalism and Hybridity in Mongolia*). Oxford: Clarendon Press.  
Гонгор Д.  
1970, 1978. “Халх товчоон”. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи. Нацагдорж Ш.  
1963. “Халхын түүх”. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи.  
Очир А. Сэржээ Ж.  
1996. “Монголчуудын овгийн лавлах”. Улаанбаатар ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн хэвлэх хэсэг.  
Ринчен Б.  
1968. “Монгол Ард Улсын Хамниган Аялгуу”. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи.  
1969 [1979]. “Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”, Удиртгал. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи.  
1979 (хян.). “Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи.  
2002. “Монголын за – Андагаар буй за”. Улаанбаатар: Интерпресс.  
Сумьяабаатар Б. 1966. “Буриадын угийн бичээс”. Улаанбаатар: БНМАУ Шинжлэх Ухааны Академи.  
Цэрэнханд Г.  
1965 [2005]. “БНМАУ-д социалист ахуйг судлан эхэлж байгаа нь”. Цэрэнханд 2005-д.  
1972 [2005]. “Хөдөө аж ахуйн нэгдэлчдийн өрх гэр, гэр ахуй”. Цэрэнханд 2005-д.  
1972 [2005]. “Шинэ хэв заншил бүрэлдэн тогтох хөгжлийн зарим асуудал”. Цэрэнханд 2005-д.  
1981 [2005]. “Нэгдэлч малчдын аж байдал”. Цэрэнханд 2005-д.  
1987 [2005]. “Буриадын гарал үүсэлд холбогдох тэмдэглэл”. Цэрэнханд 2005-д.  
2005. “Монголчууд: Угсаа Соёл, Зан Заншил”. 1 ба 2-р боть. Улаанбаатар: Адмон

Цэрэнханд Г, Билэгт Л.

“Овог хэмээх нэр томъёоны орчин үеийн ойлголтыг судалсан урьдчилсан дүнгээс”. Цэрэнханд 2005-д.

Цэвээн Ж.

1930 [1997]. “Монгол улсын эрдэм шинжилгээний ажлын ач холбогдол”. Цэвээн 1997-д.

1934 [1997]. “Дархад, Хөвсгөл нуурын Урианхай, Дөрвөл, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Дарьганга, Алтайн Урианхай, Хасаг, Хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл”. Цэвээн 1997-д.

1997. “Түүвэр зохиолууд”, боть.1. Улаанбаатар: Монголын Үндэсний Түүхийн Музей.

Цэвээн Ж, Ринчэн Б.

[1997]. “Монгол газар орны байдал: Монгол газар орны шинжилгээний ерөнхий байдал”. Цэвээн 1997-д

Орчуулсан Б.Цэцэнцолмон

**STUDIA ETHNOLOGICA  
INSTITUTI HISTORIAE ACADEMIAE SCIENTIARUM  
MONGOLI**

---

**Tomus XX**

**Fasciculus 1-23**

**УГСААТАН СУДЛАЛ**

**БОТЬ XX**

Эрхэлсэн. С.Чулуун  
Б.Баатархүү

УЛААНБААТАР  
2011